

Эрдэм шинжилгээний байгууллага болон хүний нөөцийн хөгжил, Монгол судлал хариуцсан ахлах шинжээч, Лхамсүрэн Мөнхтуяа

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ: ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗӨРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;							
1	Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийн төслийг боловсруулах /"Brain Drain-Brain Gain" тусгайлсан хөтөлбөр	Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/	-	Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийн төслийг боловсруулсан /"Brain Drain-Brain Gain" тусгайлсан хөтөлбөр/ байна. /баримт бичиг 1/	Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг 2026-2028 онд хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийн 6 зорилтын хүрээнд боловсруулсан. Тус хөтөлбөрийн төслийг салбарын хэмжээнд хэлэлцүүлж, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.20 дахь заалтын дагуу сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. Хавсралт: 1 файл	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Шинжлэх ухаан, технологийн шагнал олгох журмын төслийг боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/	Засгийн газрын 2007 оны 147 дугаар тогтоолоор	Шинжлэх ухаан, технологийн шагнал олгох журмын төслийг боловсруулсан	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 35 дугаар зүйлд шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал болох "Байгаль, нийгмийн ухааны шагнал",	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

			баталсан журам	байна. /баримт бичиг 1/	"Технологийн дэвшлийн шагнал", "Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал"-ыг олгох журмыг МУ-ын Засгийн газар батлахаар заасан. Тус зохицуулалтын хүрээнд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн "Журам батлах, шагналын хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Засгийн газрын гишүүдээс санал авахаар албан бичгийг боловсруулан удирдлагаар хянагдаж байна. Хавсралт: 1 файл	11-р сар, 12-р сар	
--	--	--	----------------	-------------------------	--	-----------------------	--

3.1. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3	Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн шинжлэх ухаан, технологийн бүлгийг боловсруулна.	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн шинжлэх ухаан, технологийн бүлгийг боловсруулсан байна.	"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд "Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун" бодлогын чиглэлийг Үндэсний түвшний 1 үр дүн, салбарын 2 үр дүн, ТЭЗ-ийн 3 үр дүн, хөтөлбөрийн 7 үр дүн, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлон боловсруулсан. Мөн Шинжлэх ухаан, технологийн салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээг тодорхойлсон. - "МУ-ыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-ийн төслийг боловсруулахад ЭЗХЯ-ны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	--	--	---	--	--	------

					<p>харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, ШУА, их сургуулийн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Ажлын хэсгийг байгуулж, санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг тусгах ажлыг зохион байгуулсан. - "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төслийг Шинжлэх ухааны академийн төрөлжсөн 2 академи, 6 салбарын Бага чуулган, Их чуулганы хуралд хэлэлцүүллээ. Баримт бичгийн төсөлд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдаас хэл зүй, найруулгын санал, зөвлөмж гаргуулан баримт бичгийг сайжруулан эцэслэж, холбогдох газар нэгж, дээд байгууллагад хүргүүлсэн. -УХОХ-т санхүүжилт шаардлагатай 1 арга хэмжээ, ТЭЗҮ шаардлагатай 3 арга хэмжээний саналыг боловсруулан хүргүүлснээс санхүүжилт шаардлагатай 1 арга хэмжээ батлагдсан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 2 файл</p>		
4	Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Баримт бичгийн тоо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 365 дугаар тушаалаар баталсан "Шинжлэх	Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.	"Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журам"-ыг шинэчлэн боловсруулсан. Журмыг сайдын тушаалаар батлуулахаар тушаалын төслийг боловсруулсан. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	100%

			ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журам"		цахим хуудсанд журмын төслийг нээлттэй байршуулж 2025.11.17-ны өдрөөс 2025.11.30-ны өдрүүдэд санал авч, ирсэн саналыг дээрх төсөлд тусгасан болно. https://med.gov.mn/post/169353 . Тус журмыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэгч Монголын Шинжлэх ухааны академиас саналыг авч төсөлд тусгасан. 2025 оны 12-р сард багтаан батлагдана.	10-р сар, 11-р сар, 12-р сар	
5	Залуу судлаач, эрдэмтэнд судалгааны грант олгох журмыг шинэчлэн батлуулна.	Баримт бичгийн тоо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 324 дугаар тушаалаар баталсан "Сайдын нэрэмжит грант олгох тухай" журам	Залуу судлаач, эрдэмтэнд судалгааны грант олгох журмыг шинэчлэн батлуулсан байна.	"Залуу судлаачдын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, грант олгох журам"-ыг шинэчлэн боловсруулсан. Журмыг сайдын тушаалаар батлуулахаар тушаалын төслийг боловсруулж, цахим системд холбогдох удирдлагаар хянагдаж байна. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудсанд журмын төслийг нээлттэй байршуулж 2025.11.17-ны өдрөөс 2025.11.30-ны өдрүүдэд санал авч, ирсэн саналыг дээрх төсөлд тусгасан болно. https://med.gov.mn/post/169353 . Тус журмыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэгч Монголын Залуу эрдэмтдийн холбооноос саналыг авч төсөлд тусгасан. 2025 оны 12-р сард багтаан батлагдана.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

								Хавсралт: 1 файл	
3.2. Шинжлэх ухааны судалгаа, дэвшилтэт технологи, инновацыг эдийн засгийн тэргүүлэх салбаруудад нэвтрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх замаар аж ахуйн нэгжүүдийн тогтвортой өсөлтийг дэмжих, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, шинжлэх ухааны судалгааны төслийн бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг хангах;									
6	Шинжлэх ухааны ажилтны өдрийг угтсан "Шинжлэх ухаан, технологи-инновац-2025" арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь /хувь/	Жил бүр тогтмол	"Шинжлэх ухаан, технологи-инновац-2025" арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана. /100 хувь/	Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 204 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.5 дахь заалтад заасны дагуу 2025 оны шинжлэх ухааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/56 тоот тушаалаар, баталсан. "Шинжлэх ухаан – 2025" баярын арга хэмжээг 2024 оны 12-р сарын 05-ны өдөр салбарын 400 гаруй албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр салбараа үр бүтээлтэй ажилласан салбарын албан хаагчдад төрийн дээд одон медаль болон Залуу судлаачдын грант, Докторын дараах сайдын нэрэмжит грантыг гардуулсан. Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%		
7	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт 2025 оноос эхлэн хэрэгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн	2025 онд хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн тоо /Тоо/	Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" А/497 дугаар тогтоол	Сонгон шалгаруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, холбогдох шийдвэрийг баталгаажуулж,	Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын дагуу 2025 оноос эхлэн хэрэгжих суурь, технологийн туршилт зүгшрүүлэлтийн төсөл болон	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	100%		

	ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.			хэрэгжилтийг хангасан байна. /нийт 65 төсөл/	хамтарсан төслийн мэдүүлгийг ШУТС-ийн цахим системээр авч, шинжээчийн олонхын санал дүгнэлт авсан нийт 171 төслийг шинжлэх ухааны 7 салбар чиглэлээр сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Мэргэжлийн хорооны хурлаар хэлэлцүүлж, 2025 онд шинээр хэрэгжих нийт 60, үүний 51 нь суурь судалгааны, 9 нь технологийн туршилт зүгшрүүлэлтийн төсөл хэрэгжихээр шийдвэр гаргасан байна. - Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам Оросын Холбооны Улсын Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны сан (РНФ) хооронд байгуулсан санамж бичгийн дагуу 2026 оноос хамтран хэрэгжүүлэх суурь судалгааны болон хавсарга судалгааны төслийн уралдааныг 2025 оны 11-р сарын 28-ны өдөр хүртэл зарласан бөгөөд нийт 82 хамтарсан төслийн саналыг ирүүлээд байна. Хавсралт: 2 файл	10-р сар, 11-р сар, 12-р сар	
8	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлыг удирдлагаар хангаж ажиллана.	Барилгын ажлын гүйцэтгэлийн явц, хувиар	-	Цогцолборын барилгын гүйцэтгэл 75 хувьд хүрсэн байна.	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Шинжлэх Ухааны Академийн эзэмшлийн 4.8 га талбайд баригдаж байна. Олон улсын стандартад нийцсэн, салбар дундын төрөлжсөн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	100%

					<p>лаборатори бүхий энэхүү цогцолборын баригдахаар төлөвлөгдсөн 7 объектоос 27,000 м2 ашиглалтын талбай бүхий лабораторийн 3 барилга болон тусгай зориулалтын агуулахын барилгууд болон оффисын хоёр барилгын угсралтын явц 80 гаруй хувьтай явагдаж байгаа бөгөөд цогцолбор нь бүхэлдээ 2026 онд ашиглалтад орох юм. Тус цогцолборт Шинжлэх Ухааны Академи түүний харьяа эрдэм шинжилгээний 16 хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны паркийн захиргаа, Анагаах ухаан хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн. Одоогийн байдлаар тус цогцолборын эхний ээлжийн барилгууд ашиглалтад орж нийт 7 хүрээлэнгийн 500 гаруй судлаачид таатай орчинд судалгааны ажлаа хийж эхлээд байна.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 5 файл</p>	10-р сар, 11-р сар, 12-р сар	
9	Шинжлэх ухаан, технологийн салбарын нэгдсэн статистик, салбарын нэгдсэн суурь үзүүлэлт, тоон мэдээллийг батлагдсан	Үндэсний статистикийн хорооноос баталсан албан ёсны маягтын дагуу нэгтгэн гаргасан мэдээ	2023 оны статистикийн албан ёсны мэдээ	-	Шинжлэх ухаан, технологийн салбарт 2024 онд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын статистик мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны А/71 дугаар тушаалаар баталсан албан ёсны ШУТ-1-8 дугаар маягтын дагуу гарган тус	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар,	100%

маягтаар нэгтэн гаргаж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ.				хороонд хүргүүлсэн. Хавсралт: 2 файл	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцсан чиг үүргийн хүрээнд олон улсын хурал, зөвлөгөөнд биечлэн болон цахимаар оролцох, туршлага судлах	Хариуцсан чиг үүргийн хүрээнд олон улсын хурал, зөвлөгөөнд биечлэн болон цахимаар оролцох, туршлага судлах	Хариуцсан чиг үүргийн хүрээнд олон улсын хурал, зөвлөгөөнд биечлэн болон цахимаар оролцох, туршлага судлах	Хариуцсан чиг үүргийн хүрээнд олон улсын хурал, зөвлөгөөнд биечлэн болон цахимаар оролцох, туршлага судалсан байна. (100%)	БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос 2025 оны 10-р сард зохион байгуулсан "Хятад-ШХАБ-ын Ногоон үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа" сэдэвт семинар болон "Ногоон аж үйлдвэрлэлийн шинэ платформ хамтдаа бүтээж, бүс нутгийн хамтын ирээдүйг цогцлоох нь" сэдэвт форумд оролцож, ногоон аж үйлдвэрлэлийн чиглэлээр өргөн хүрээний мэдлэг олж авсан. Тус форумын тайланг холбогдох журмын дагуу	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ТЗУГ-т хүлээлгэн өгсөн. Хавсралт: 1 файл		
2	Тогтмол зохион байгуулдаг Мэдээллийн цагт оролцсон байна.	Тогтмол зохион байгуулдаг Мэдээллийн цагт оролцсон байна.	Тогтмол зохион байгуулдаг Мэдээллийн цагт оролцсон байна.	Тогтмол зохион байгуулдаг Мэдээллийн цагт оролцсон байна. (100%)	Төрийн нарийн бичгийн даргын баталсан хуваарийн дагуу зохион байгуулагдсан "Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах", "Монгол Улсад тогтвортой дэд бүтцийн хөгжил болон ногоон санхүүжилт", "Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх", "Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж", "Healthy is the new cool" сэдэвт нийт 5 Мэдээллийн цагт тогтмол оролцсон. Мөн хуваарийн дагуу 2025 оны 10-р сарын 30-ны өдөр Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын хуваарьт Мэдээллийн цагийг зохион байгуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ХЯНАСАН:

Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батболд Мөнхтөр /...../

Огноо: 12.15/2025

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрдэм шинжилгээний байгууллага болон хүний нөөцийн хөгжил, Монгол судлал хариуцсан ахлах шинжээч, Лхамсүрэн Мөнхтуяа

/...../

Огноо: 2025.12.12

